



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 204 тоот, 3 дугаар баг,

Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083

Утас: (976) 70532849, Факс: (976) 70532111

Цахим хаяг: info@omnogovi.gov.mn

Цахим хуудас: www.omnogovi.gov.mn

2025.05.23 № 02/2098
танай _____ -ны № _____ -т

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ**

Нээлттэй засгийн түншлэл санаачилгын хүрээнд “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” арга хэмжээг ирүүлсэн удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн иргэд, төрийн алба хаагчдыг хамруулан 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээний тайлан, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4. хуудастай.

ДАРГА



Ц.АМАРТӨГС

4625080587

Handwritten signature and red official stamp.

Handwritten text in Mongolian script, likely a letter or official communication.

Handwritten text in Mongolian script.

Handwritten text in Mongolian script.

Handwritten text in Mongolian script.

Handwritten text in Mongolian script.

Handwritten text in Mongolian script.

“Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” арга хэмжээний тайлан

Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар хэрэгжүүлж буй “Нээлттэй засгийн түншлэл” хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног – 2025” арга хэмжээг Өмнөговь аймагт амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээ нь нээлттэй засаглал, ил тод байдал, хариуцлагатай үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий олон талт сургалт, хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөг, цахим үйлчилгээний танилцуулга, явуулын оффис зэрэг үйл ажиллагааг багтаасан юм.

Үндсэн үйл ажиллагаанууд

- Нээлттэй засгийн түншлэлийн талаарх танилцуулга, санаачилгын ойлголтыг иргэдэд хүргэх
- Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлын талаарх видео сургалт
- “И-Бизнес” платформын нэгдсэн танилцуулга
- Кибер аюулгүй байдал, төрийн мэдээллийн системүүдийн хэрэглээ, үүлэн тооцооллын танилцуулга
- ЖДҮ болон хувиараа бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, мэдээлэл
- “Бизнес ба хүний эрх” сэдвээр цахим сургалт зохион байгуулсан

Үр дүн

Арга хэмжээнд нийт 1,000 гаруй иргэн, төрийн албан хаагч, бизнес эрхлэгч хамрагдсан бөгөөд орон нутгийн төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн ажилтнуудад зориулсан мэргэшүүлэх сургалт, нэгдсэн уулзалт зохион байгуулсан болно.

Хаалтын үйл ажиллагаагаар хийсэн ажлуудын үр дүнг нэгтгэн хэлэлцэж, Нээлттэй засгийн түншлэлийн үнэт зүйлсийг орон нутгийн бодлого төлөвлөлтөд хэрхэн тусгах талаар хэлэлцсэн юм.

Зурагт агшин

Доорх зурагт агшинууд нь арга хэмжээний үеэр авсан үйл ажиллагааны товч илэрхийлэл юм.

Дүгнэлт

“Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног – 2025” арга хэмжээ нь орон нутгийн иргэд, төрийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, ил тод, хариуцлагатай засаглалын зарчмыг түгээн дэлгэрүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан амжилттай арга хэмжээ боллоо.

📷 Зураг 1: Нээлттэй хэлэлцүүлгийн үеэр




📷 Зураг 2: Иргэдийн оролцоотой сургалтын агшин



📷 Зураг 3: Кибер аюулгүй байдлын танилцуулга



Зураг 4: Цахим хуудсанд байршуулсан байдал



Зураг 5: Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлын талаарх видео илгээсэн байдал

